

ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ
СУДАЛГААНЫ ТАЙЛАН

2024 он

ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Нэг.Ерөнхий зүйл

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна” гэж, мөн зүйлийн 4 дэх хэсэгт “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна” гэж тус тус заасан.

Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2-т “Эдийн засгийн олон тулгуурт, оновчтой бүтцийг бий болгох, хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлого явуулах, санхүүгийн салбарын аюулгүй байдлыг баталгаажуулах, эрчим хүч, эрдэс баялгийн болон гадаад худалдаа, интеграцийн асуудлаар оновчтой бодлого баримтална.” гэж тусгасан.

Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилго 4-т “Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга зонхилсон, ядуурал эрс буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, дотоод хэрэгцээгээ өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа бүрдүүлсэн, олон тулгуурт эдийн засагтай улс болно” гэж заасан бөгөөд энэ зорилгын хүрээнд нийцүүлэн тодорхойлсон эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг төрийн бодлогоор онцгойлон дэмжихээр тусгасан. Уг зорилгыг хэрэгжүүлэх I үе шат (2021-2030)-нд “Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих нөхцөл бүрдсэн байна”, “Хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлж, төр хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлсэн байна”, “Гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, зохицуулалтын орчныг сайжруулна” гэж тус тус заасан.

Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 5.2.3-т “гадаад хөрөнгө оруулалт, худалдааг дэмжсэн төрийн зохицуулалтыг боловсронгуй болгож, нэг цонхны нэгдмэл бодлого хэрэгжүүлж хэвшинэ” гэж заасан.

Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.3.5-т “Хөрөнгийн зах зээлд мэргэжлийн оролцогчдын хүрээг тэлэх бодлого хэрэгжүүлж, гадаадын хөрөнгө оруулагчдыг татах татварын таатай орчныг бүрдүүлнэ” гэж, 3.2.2.2-т “Хөрөнгө оруулалтын тухай хууль болон бизнесийн үйл ажиллагааг зохицуулж байгаа хуулиудыг шинэчилж, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, бизнес эрхлэгчийг дэмжих эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.” гэж, 4.4.2.15-т “Монгол Улсын хөгжлийн бодит хэрэгцээ, шаардлагыг хангахуйц эдийн засаг, нийгмийн ач холбогдол бүхий томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд эдийн засгийн гадаад харилцаа, гадаадын хөрөнгө оруулалтын чиглэлд төрийн бодлого, үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, үр өгөөжийг дээшлүүлнэ.” гэж заасан.

Улсын Их Хурлын 2024 оны 64 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын бүсүүдийн хөгжлийн нийтлэг зорилгод “Улсын төсвийн хөрөнгө оруулалт, гадаад зээл, тусламж, орон нутгийн төсөв, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хөрөнгө оруулалт болон бусад эх үүсвэрийг оновчтой хуваарилна”, “Бүс, орон нутагт өндөр технологи, инновацыг нэвтрүүлнэ”, “Татвар, санхүүгийн ялгаатай бодлогыг хэрэгжүүлнэ.” гэж тус тус заасан байна.

Хөрөнгө оруулалт татахад бодлого, эрх зүйн орчноо хөрөнгө оруулагчдад сурталчлан таниулах, зорилтот улс, бус нутаг, эдийн засгийн салбар, тэргүүлэх чиглэлээр нь хөрөнгө оруулалт шаардлагатай төсөл, арга хэмжээг санал болгох, сурталчлах, хөрөнгө оруулалт татах бизнес уулзалт, форум, арга хэмжээг зохион байгуулах ажлыг эрчимтэй зохион байгуулах, цаашлаад гадаадын хөрөнгө оруулагчид Монгол Улсад хөрөнгө оруулалт хийж, үйл ажиллагаагаа эхлүүлэхэд нь шаардлагатай төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх, мэдээллээр хангах, хууль тогтоомжид заасан дэмжлэг, урамшууллыг бодитоор үзүүлэх, эрх ашгийг хамгаалах, баталгаагаар хангагдах нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай.

Үүний тулд Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн зохицуулалт, түүний хэрэгжилт тогтвортой, бодитой бөгөөд үр дүнтэй, хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулах сонирхлыг татахуйц байх шаардлагатай.

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Хөрөнгө оруулалтын тухай хуульд хөрөнгө оруулалт татах, хөрөнгө оруулалтын орчныг сурталчлах, хөрөнгө оруулагчид үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага буюу Эдийн засаг, хөгжлийн яам дангаараа хэрэгжүүлэхээр заасан нь хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан зорилго, зорилтыг үр дүнтэй, бүрэн хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдал үүсэх эрсдэлтэй байна.

Түүнчлэн хөрөнгө оруулагч нарын хувьд хамгийн их тулгамддаг асуудал нь төрийн үйлчилгээг хүнд сурталгүй авах, улмаар төрийн байгууллагын буруутай үйлдлээс эрх ашиг нь хөндөгдсөн тохиолдолд эрх бүхий байгууллагад гомдол гаргах механизмыг хялбаршуулах, улмаар оруулсан хөрөнгө оруулалтаа хамгаалуулах, хууль ёсоор хураан авсан тохиолдолд нөхөн төлбөрийг үл маргах журмаар авдаг байх, зөрчигдсэн эрх ашгаа хамгаалуулахаар арбитра хандах нөхцөл журмыг маш тодорхой хуульчлах шаардлагатай байгааг үндэслэн хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилгоор Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн төслийг боловсруулсан байна. Тус хуулийн төсөл нь нийт 5 бүлэг, 25 зүйлтэй.

Хоёр.Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгосон байдал, үндэслэл

Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалд тусгагдсан үндсэн асуудлыг зохицуулахаар зорьсон чиглэл тус бүрээс хуулийн төслийн зорилтыг хамгийн сайн илэрхийлж чадах зохицуулалтыг сонгож, хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай холбогдуулан,

аргачлалд дурдсан “зорилгод хүрэх байдал”, “ойлгомжтой байдал”, “зардал”, “харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлгээ хийхээр сонгож авсан.

Сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үр нөлөөг үнэлэхэд хамруулах хэсэг, түүнийг шалгах хэрэгслийг хүснэгт 1-д үзүүлсний дагуу тогтоосон.

Хүснэгт 1. Шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилтыг хангах эсэхэд дүн шинжилгээ хийх.
2	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийг зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 24, 28, 29, 30, 32 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах.
3	Зардал	Хуулийн төслийг зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хуулийн төслийн нөлөөллөөс иргэн аж ахуйн нэгж байгууллага, төрийн байгууллагад гарах нэмэгдэл зардлыг үнэлж тооцох.
4	Харилцан уялдаа	Хуулийн төслийг зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.5-т болон аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурыг хангасан шалгах.

Гурав. Хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгийг тогтоосон байдал

3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад тухайн хуулийн төслийн зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийхийг зорьсон.

Тус хуулийн төслийн үзэл баримтлалаар дараах зорилтыг дэвшүүлсэн байна.

1.Хуулийн нэр томъёоны тодорхойлолтыг оновчтой, ойлгомжтой болгож, хөрөнгө оруулалтын баталгаа, хөрөнгө оруулалтын хэлбэр, хөрөнгө оруулагчийн эрх, үүрэг, хууль хэрэгжүүлэхтэй холбоотой нарийвчилсан зохицуулалт шаардсан хэм хэмжээний акт батлах байгууллага, албан тушаалтны эрх хэмжээг тодорхойлж, хуулийг нэг мөр хэрэгжүүлэх боломж бүрдүүлэх;

2. Энэ хуулийн хүрээнд зохицуулах харилцаанд дараах зарчмыг баримтлах:

- Тогтвортой байх
- Хууль дээдлэх
- гадаадын хөрөнгө оруулагчийн эрх зүйн байдлыг дордуулах хуулийг буцаан хэрэглэхгүй байх;
- төр гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх;
- Нээлттэй, ил тод байх

3. Хуулийн төсөлд гадаадын хөрөнгө оруулалтын талаарх Гадаадын хөрөнгө оруулалтын үндэсний зөвлөл болон тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрх, үүргийг шинээр тусгаж, төрийн байгууллагын үйл ажиллагааны нэгдмэл байдал, уялдааг хангах нөхцөлийг бүрдүүлэх;

4. Засгийн газар гадаадын хөрөнгө оруулалт, худалдааны асуудал хариуцсан Засгийн газрын гишүүнээр ахлуулсан Гадаадын хөрөнгө оруулалтын үндэсний зөвлөлийг төрийн болон хараат бус 9 гишүүний төлөөллийн бүрэлдэхүүнтэй байгуулах болон зөвлөлийн эрх, үүргийн асуудлыг энэхүү хуулиар тодорхойлно. Энэ зөвлөл нь гадаадын хөрөнгө оруулалтын талаарх хууль тогтоомжийн төсөлд санал өгөх, дүгнэлт гаргаж, Засгийн газарт хүргүүлнэ. Түүнчлэн, гадаадын хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор төрийн байгууллага, албан тушаалтны үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзвэл гомдол хүлээн авч, шийдвэрлэх зохицуулалт оруулж, олон улсын сайн туршлагыг нэвтрүүлэх;

5. Хуулийн төсөлд Монгол Улсын хөгжлийн бодлогод тодорхойлогдсон эдийн засгийн тэргүүлэх салбаруудад оруулах гадаадын хөрөнгө оруулалтад олгох нэн таатай болон таатай нөхцөл, дэмжлэг, урамшууллыг тодорхойлж, хөрөнгө оруулалтаа хийж буй эсэхэд хяналт тавих зохицуулалтыг тусгана. УИХ гадаадын хөрөнгө оруулалт татах салбарын тэргүүлэх чиглэлийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр тодорхойлно.

6. Хөрөнгө оруулагч болон хөрөнгө оруулахаар сонирхож буй аж ахуйн нэгжүүдэд зориулсан хууль, эрх зүйн болон хөрөнгө оруулалтын орчныг сурталчлах, хөрөнгө оруулагчдад туслалцаа үзүүлэх үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг нарийвчлан тусгаж, хөрөнгө оруулагчдад зөвлөх, дэмжих, бизнесийн орчны мэдээлэл хүргэх зэрэг үйлчилгээг нэг цонхоор, цахимаар үзүүлэх боломжийг бүрдүүлэхээр тусгана.

Иймд үзэл баримтлалын төсөлд тусгасан эдгээр зорилтод Хуулийн төсөл нийцэж байгаа эсэхийг үнэлэв.

Хуулийн төслийн үзэл баримтлал	Хуулийн төслийн зохицуулалт
Хуулийн нэр томъёоны тодорхойлолтыг оновчтой, ойлгомжтой болгож, хөрөнгө оруулалтын баталгаа, хөрөнгө оруулалтын хэлбэр, хөрөнгө оруулагчийн эрх, үүрэг, хууль	Хуулийн төслийн 4 дүгээр зүйлд хуульд хэрэглэгдэх нэр томъёог дахин нарийвчлан тодорхойлсон байна. -Гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн тухай ойлголтын хүрээнд гадны

<p>хэрэгжүүлэхтэй холбоотой нарийвчилсан зохицуулалт шаардсан хэм хэмжээний акт батлах байгууллага, албан тушаалтны эрх хэмжээг тодорхойлж, хуулийг нэг мөр хэрэгжүүлэх боломж бүрдүүлэх тухайд</p>	<p>хөрөнгө оруулагч хувьцааны 25 түүнээс дээш хувийг эзэмсэн байх, оруулах хөрөнгийн доод хэмжээг Засгийн газар тогтоохоор тусгажээ.</p> <p>-Гадаадын хөрөнгө оруулалтын талаарх төрийн дэмжлэг, зохицуулалт, үйл ажиллагаанд тавигдах хязгаарлалтыг тогтоохтой холбоотой “Сөрөг жагсаалт”, “Үндэсний тааламжтай нөхцөл” гэсэн ойлголтыг тодорхойлжээ.</p> <p>-Хуулийн төслийн 5, 6, 7 дугаар зүйлүүдэд гадаадын хөрөнгө оруулалтад баримтлах бодлого, зарчим, гадаадын хөрөнгө оруулалт хийх хүрээ, хөрөнгө оруулагчийн эрх, үүргийн талаар зохицуулалтуудыг тусгажээ.</p> <p>-Хуулийн төслийн 4 дүгээр зүйлд гадаадын хөрөнгө оруулагчаас шууд болон шууд бусаар явуулж буй үйл ажиллагаанд хамаарах хөрөнгө оруулах хэлбэрүүдийг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Хөрөнгө оруулалтын тухай хуульд зааснаас илүү нарийвчлан, ойлгомжтой байдлаар тодорхойлжээ.</p> <p>-Хуулийн төслийн 11, 12 дугаар зүйлд Гадаадын хөрөнгө оруулагчид үзүүлэх хөрөнгийн болон үйл ажиллагааны баталгааг тодорхойж, хууль бусаар хөрөнгө дайчлан авахгүй байх, дайчлан авсан нөхөн олговрыг шуурхай олгох, орлого, хөрөнгийг гадаадад саадгүй гуйвуулах, үйл ажиллагаагаа явуулахад дотоодын хөрөнгө оруулагчийн нэгэн адил нөхцөлөөр хангагдах, төрийн байгууллага үндэслэлгүйгээр үйл ажиллагааг хязгаарлах хориглох, эс үйлдэл гаргах зэрэг албан тушаалтны үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тогтоож өгснөөр хөрөнгө оруулагч нь үйл ажиллагаагаа баталгаатай, чөлөөтэй явуулах боломжийг бүрдүүлэхээр байна.</p> <p>-Засгийн газар тогтворжуулах гэрчилгээ олгох шалгуур, хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах нөхцөл журмыг тодорхойлохоор заажээ.</p> <p>Иймд тус хуулийн төсөл нь үзэл баримтлалд тусгагдсан нэгдүгээр зорилтыг хангаж байна.</p>
<p>Энэ хуулийн хүрээнд зохицуулах харилцаанд тогтвортой байх, хууль дээдлэх, хөрөнгө</p>	<p>Хуулийн төслийн 5 дугаар зүйлд гадаадын хөрөнгө оруулалтад баримтлах бодлого, зарчмыг тусгахдаа төрөөс гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих тогтолцоог бүрдүүлж, боловсронгуй болгон, хөрөнгө оруулалтад</p>

<p>оруулагчийн нөхцөлийг дордуулсан хуулийг буцаан хэрэглэхгүй байх, төр гэрээний үүргээ биелүүлэх, нээлттэй, ил тод байх зарчмыг баримтлах тухайд</p>	<p>нээлттэй, тааламжтай нөхцөлийг олгон, зах зээлийн тогтвортой, ил тод, урьдчилан таамаглахуйц, орчныг бүрдүүлэх талаар тусгажээ.</p> <p>-Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийг шинэчлэн батлах, нэмэлт өөрчлөлт оруулах, хөрөнгө хураах, дайчлан авах, хориглохтой холбоотой аливаа шийдвэр гаргахад УИХ-ын гишүүд заавал хүрэлцэн ирсэн байхаар зааснаар хуулийн тогтвортой байдлыг хадгалахад нөлөөлөхүйц хуулийн механизм болно гэж үзэж байна.</p> <p>- Гэрээний харилцаан дахь төрийн байгууллагын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэхэд чиглэсэн зохицуулалтыг тусгажээ. Хуулийн төслийн 12 дугаар зүйлд гадаадын хөрөнгө оруулагчийн үйл ажиллагааны баталгааг зааж, хөрөнгө оруулагч нь ёсны эрх, ашиг сонирхлыг хууль тогтоомж зөрчиж байна гэж үзвэл холбогдох хууль тогтоомжийн дагуу гомдол гаргах эрхтэй бөгөөд төр гомдлыг цаг тухайд нь хүлээн авч, шийдвэрлэх талаар тусгасан байна.</p> <p>-Төрийн байгууллагын гадаадын хөрөнгө оруулалттай холбоотой үйл ажиллагаанд хуулиас гадуур аливаа хориглолт, хязгаарлалт, нэмэлт шаардлага тавих, эс үйлдэл гаргахыг хориглосон нь үр дүнтэй зохицуулалт болжээ.</p> <p>Түүнчлэн “Гадаадын хөрөнгө оруулалтын үндэсний зөвлөл” (Зөвлөл)-тэй байхаар тусгаж, зөвлөл нь гомдлыг хүлээн авч, хэлэлцээд, холбогдох төрийн байгууллагад үүрэг чиглэл өгөх, шийдвэрээ Засгийн газарт хүргүүлэх, шийдвэрийнхээ биелэлтийг сонсож хэлэлцэх зэргээр хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, гомдол шийдвэрлэх үр дүнтэй бүтцийг бий болгожээ.</p> <p>-Хуулийн төслийн 10 дугаар зүйлд Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдаатай холбоотойгоор төрийн бусад үйлчилгээ, зөвлөгөөг цахим нэг цонхны үйлчилгээгээр хүргээ үзүүлэх, Зөвлөлд ирүүлсэн гомдол, холбогдох хавсаргасан</p>
--	--

	<p>нотлох баримтын бүртгэлийг мэдээллийн сангийн цахим системд бүртгэх талаар тус тус тусгасан нь хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдсан хоёрдугаар зорилтыг хангаж байна.</p>
<p>Гадаадын хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүнээр ахлуулсан гадаадын хөрөнгө оруулалтын зөвлөл байгуулах болон зөвлөлийн эрх, үүргийн асуудлыг энэхүү хуулиар тодорхойлно.</p> <p>Энэ зөвлөл нь гадаадын хөрөнгө оруулалтын бодлогын талаар санал, зөвлөмжүүдийг боловсруулна. Түүнчлэн, гадаадын хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор төрийн байгууллага, албан тушаалтны үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсэн гэж үзвэл гомдол хүлээн авч, шийдвэрлэх, зохицуулалт оруулж, олон улсын сайн туршлагыг нэвтрүүлэх тухайд</p>	<p>Хуулийн төслийн 2 дугаар бүлэгт Зөвлөл байгуулах болон түүний эрх үүргийг, 5 дугаар бүлгээр гомдол хянан шийдвэрлэх ажиллагааг зохицуулсан.</p> <p>-Хуулийн төслийн 21 дүгээр зүйлд гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд, гадаадын хөрөнгө оруулагч нь төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус үйлдэл, эс үйлдэхүйн улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн тухай гомдлыг Гадаадын хөрөнгө оруулалтын зөвлөлд гаргаж болно гэж тусгаж өгсөн. Зөвлөл нь гомдлыг хүлээн авч, хэлэлцээд зөвлөмж, санал гаргаж, холбогдох төрийн байгууллага болон Засгийн газарт шийдвэрийг хүргүүлэх, холбогдох төрийн байгууллага нь Зөвлөлөөс гаргасан шийдвэрийн хэрэгжилтийн биелэлтийн талаар Засгийн газар болон Зөвлөлд тайлагнах талаар процесс ажиллагааг нарийвчлан тусгаж өгсөн байна.</p> <p>Мөн хуулийн төслийн 5 дугаар бүлэгт хөрөнгө оруулагч болон төрийн байгууллага хооронд үүссэн хөрөнгө оруулалттай холбоотой маргааныг шийдвэрлэх арга замыг тусгаж өгсөн байна. Тухайлбал, хуулийн төсөлд талууд хөрөнгө оруулалтын маргааныг 6 сарын дотор хэлэлцээний замаар шийдвэрлэх, уг хугацаанд шийдвэрлэж чадаагүй тохиолдолд арбитраар шийдвэрлүүлэх талаар тусгажээ.</p> <p>Иймд тус хуулийн төсөл нь үзэл баримтлалд тусгагдсан гуравдугаар зорилтыг хангаж байна.</p>
<p>Хуулийн төсөлд гадаадын хөрөнгө оруулалтын талаарх төрийн байгууллагын эрх үүрийг тодорхойлж, үйл ажиллагааны нэгдмэл байдал, уялдааг хангах нөхцөлийг бүрдүүлэх тухайд</p>	<p>Хуулийн төслийн 2 дугаар бүлэгт хөрөнгө оруулалтыг дэмжих төрийн чиг үүрэг, Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас үзүүлэх үйлчилгээ, Гадаадын хөрөнгө оруулалтын зөвлөлийн чиг үүргүүдийг тогтоож өгсөн.</p> <p>Гадаадын хөрөнгө оруулалт, худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага төрийн үйлчилгээний нэг цонхны цахим үйлчилгээ үзүүлэх, гадаадын хөрөнгө</p>

	<p>оруулагч, гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн төрд байгаа мэдээллийг төрийн холбогдох байгууллагуудын мэдээллийн сангаар дамжуулан авах зэргээр төрийн байгууллагууд нь үйл ажиллагаагаа гадны хөрөнгө оруулагчид нэмэлт үүрэг хүлээлэхгүйгээр уялдуулах, давхардал, хийдэл үүсгэхгүй байх заалтыг тусгажээ.</p> <p>Иймд тус хуулийн төсөл нь үзэл баримтлалд тусгагдсан дөрөвдүгээр зорилтыг хангаж байна.</p>
<p>Хуулийн төсөлд Монгол Улсын хөгжлийн бодлогод тодорхойлогдсон эдийн засгийн тэргүүлэх салбаруудад оруулах гадаадын хөрөнгө оруулалтад олгох нэн таатай болон таатай нөхцөл, шууд болон шууд бус урамшууллыг тодорхойлж, хөрөнгө оруулалтаа хийж буй эсэхэд хяналт тавих зохицуулалтыг тусгана. Засгийн газар гадаадын хөрөнгө оруулах тэргүүлэх салбаруудыг УИХ-д өргөн мэдүүлж, батлуулах тухайд</p>	<p>Хуулийн төслийн 2 дугаар бүлэгт хөрөнгө оруулалтыг дэмжих төрийн чиг үүрэгт Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, нээлттэй байдлыг өргөжүүлэх зорилгоор шаардлагатай бол эдийн засгийн тусгай бүс байгуулах, тодорхой салбарт гадаадын хөрөнгө оруулалт хийх туршилтын бодлого, арга хэмжээ хэрэгжүүлж болох, төрөөс үндэсний эдийн засаг, нийгмийн хөгжлийн шаардлагын дагуу гадаадын хөрөнгө оруулагчийг тодорхой үйлдвэрлэл, салбарт хөрөнгө оруулалт хийхэд нь дэмжлэг үзүүлж, чиглүүлж болох ба энэ тохиолдолд гадаадын хөрөнгө оруулагчид болон гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдэд хууль тогтоомжид заасны дагуу давуу эрхийн хөнгөлөлтийг үзүүлж болно гэж тусгажээ.</p> <p>Түүнчлэн хуулийн төслийн 15 дугаар зүйлд Гадаадын хөрөнгө оруулалт татах тэргүүлэх салбаруудыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал батлахаар заажээ.</p> <p>Иймээс тус хуулийн төсөл нь үзэл баримтлалд тусгагдсан тавдугаар зорилтыг хангаж байна.</p>
<p>Хөрөнгө оруулагч болон хөрөнгө оруулахаар сонирхож буй аж ахуйн нэгжүүдэд зориулсан хууль, эрх зүйн болон хөрөнгө оруулалтын орчныг сурталчлах, хөрөнгө оруулагчдад туслалцаа үзүүлэх үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг нарийвчлан тусгаж, хөрөнгө оруулагчдад зөвлөх, дэмжих, бизнесийн орчны мэдээлэл хүргэх зэрэг үйлчилгээг нэг цонхоор, цахимаар үзүүлэх боломжийг бүрдүүлэх тухайд</p>	<p>Хуулийн төслийн 10 дугаар зүйлд гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг дараах байдлаар тусгасан.</p> <ul style="list-style-type: none"> - гадаадын хөрөнгө оруулалтыг татах, хадгалах, өргөжүүлэх зэрэг гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжихэд чиглэсэн цогц үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх; - гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны талаарх эрх зүйн орчин, дотоод зах зээлийн таатай нөхцөлийг

	<p>гадаадын хөрөнгө оруулагчид сурталчлах, мэдээллээр хангах;</p> <ul style="list-style-type: none"> - гадаадын хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг тогтвортой үргэлжлүүлэх, өргөтгөх, хадгалахад мэдээлэл, зөвлөгөө өгөх замаар дэмжлэг үзүүлэх; - гадаадын хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр дэмжлэг, үйлчилгээ үзүүлэх; - гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдаатай холбоотойгоор төрийн бусад үйлчилгээний талаар зөвлөх болон цахим нэг цонхны үйлчилгээ үзүүлэх; - гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны чиглэлээр төрийн бусад байгууллагаас хамтран статистик мэдээллийг гарган, мэдээллийн санг хөтлөх. <p>Хуулийн төсөлд тусгагдсан дээрх чиг үүргийг харвал үзэл баримтлалд тусгагдсан зургадугаар зорилтыг хангаж байна.</p>
--	---

3.2. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн төслийн боловсруулалт нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 24, 28, 29, 30, 32 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг шалгасан.

Хуулийн төсөл нь хэрэгжүүлэх, хэрэглэх этгээдэд ойлгомжтой байдлаар томъёологдсон эсэхийг шалгах хэрэгслийн хүрээнд иргэд, олон нийтээс хуулийн төсөлд ойлгомжгүй байгаа зохицуулалт байхгүй талаар саналаа ирүүлсэн.

<p align="center">Хууль тогтоомжийн тухай хууль 29 дүгээр зүйл. Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага</p>	
<p>29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан байх;</p>	<p>Уг шаардлагыг хангасан</p>
<p>29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;</p>	<p>Уг шаардлагыг хангасан</p>
<p>29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;</p>	<p>Уг шаардлагыг хангасан</p>

29.1.4. тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Уг шаардлагыг хангасан
29.1.5. зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Уг шаардлагыг хангасан
29.1.6. хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Уг шаардлагыг хангасан
29.1.7. бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Уг шаардлагыг хангасан
29.1.8. тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох зарчим, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журмыг тусгасан байх.	Уг шаардлагыг хангасан
30 дугаар зүйл. Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага	
30.1.1. Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Уг шаардлагыг хангасан
30.1.2. нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Уг шаардлагыг хангасан
30.1.3. үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Уг шаардлагыг хангасан
30.1.4. хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;	Уг шаардлагыг хангасан
30.1.5. жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Уг шаардлагыг хангасан

Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 24, 28 дугаар зүйлд 3.3. “Зардал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Төрд үүсэх зардал: Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд Хөрөнгө оруулалт, худалдааны газрын төсвийг баталсан тул төсөвт нэмэлт ачаалал үүсгэхгүй.

Commented [CD1]: нэмэх

Иргэнд үүсэх зардал: Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн төсөл нь иргэдэд нэмэлт зардал үүсгэхгүй.

Иргэн, аж ахуйн нэгжид: Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн төсөл батлагдсанаар аж ахуйн нэгжид нэмэлт зардал үүсгэхгүй.

Commented [E02]: Зардлын тооцооны тайлантай тулган шалгах

3.4. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан асуудлыг тодорхойлох байдлаар хуулийн төслийг бүхэлд нь авч үзсэн.

Хүснэлт 4. Хуулийн төслийн аргачлалын дагуу үнэлсэн байдал

Аргачлалд заасан асуулт	Хуулийн төслийг үнэлсэн байдал
Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	Хуулийн төсөл нь Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн зорилтыг хангахад чиглэсэн зохицуулалтыг 5 бүлэг, 25 зүйлээр нарийвчлан тодорхойлжээ. Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, баталгааг хангах, хөрөнгө оруулалтын талаар төрийн байгууллагын эрх хэмжээг тодорхойлох гомдол, иаргаан хянан шийдвэрлэх, хариуцлага, дагаж мөрдөх шилжилтийн зохицуулалт гэсэн тухайн хуулийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны той нийцэж байна.
Хуулийн төслийн нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;	Хуулийн төслөөр гадаадын хөрөнгө оруулалттай холбоотой харилцааг зохицуулах тул хуулийн төслийн нэр нь зохицуулах харилцааны агуулгад нийцсэн байна.
Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх;	Хуулийн нэр томъёоны тодорхойлолтыг Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуульд нийцүүлсэн байна.
Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	Төслийн зүйл заалт нь дотооддоо болон бусад хуультай нийцсэн байна.
Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;	Давхардал байхгүй байна.
Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;	Хуулийн төслөөр хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан байна.
Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг бүрэн тусгасан байна.
Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан, нэг чиг үүргийг хоёр өөр төрийн байгууллага гүйцэтгэх, давхардуулсан зохицуулалт байхгүй байна.	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан, нэг чиг үүргийг хоёр өөр төрийн байгууллага гүйцэтгэх, давхардуулсан зохицуулалт байхгүй байна.
Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг тусгасан. Үндэсний зөвлөлд мэргэжлийн хараат бус

	гишүүдийн бүрэлдэхүүнтэй байхаар заажээ.
Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Албан, татвар, хураамжийг тогтоосон зохицуулалт энэ хуулиар байхгүй байна.
Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;	Энэ хуулиар тусгай зөвшөөрлийн шинэ төрөл, үйл ажиллагааны зохицуулалтыг бий болгоогүй.
Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Хүний эрхийг хязгаарласан заалт байхгүй байна. Гадаадын хөрөнгө оруулалтай аж ахуйн нэгжийн хувьд үндэсний нөхцөл үйлчлэхээр тусгажээ.
Хуулийн төслийн зүйл, заалт жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	Жендерийн тэгж байдлыг хязгаарласан заалт байхгүй байна.
Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Шударга бус өрсөлдөөнийг хязгаарласан заалт байхгүй байна.
Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн зохицуулалт тусгагдаагүй.
Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Хууль бус үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хөрөнгө оруулагчийг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн буруутай албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх заалтыг тусгасан байна..

Дээрх судалгаанаас үзэхэд Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн төсөл нь Үндсэн хууль, бусад хууль тогтоомжтой уялдсан бөгөөд зөрчил, давхардалгүй байна.

Дөрөв. Үр дүнг үнэлж, зөвлөмж өгсөн байдал

Дүгнэлт: Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн төслийг “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын дагуу үнэлэхэд хуулийн төсөл нь хуулийн төслөөр тавьсан зорилгодоо хүрэх боломжтой, хуулийн төсөл боловсруулах шаардлагад нийцсэн байдлаар боловсруулагдсан байна.

- Хуулийн төслийн зорилт нь үзэл баримтлалд тусгасан асуудлыг бүрэн илэрхийлж чадсан байна.

- Хуулийн төсөлд тодорхойлсон зорилтыг хангахад чиглэсэн нэр томъёоны тайлбарууд, бодлого зарчим, хамрах хүрээ, дэмжлэг үзүүлэх, төрийн байгууллагын чиг үүрэг, гадаадын хөрөнгө оруулагчийн баталгаа, гомдол, маргааныг хянан шийдвэрлэх зэрэг зохицуулалтыг тусгасан байна.

- Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хуулийн төсөлд тавигдах шаардлагад нийцсэн бөгөөд төсөвт нэмэлт ачаалал үүсгэхгүй байна.
- Хуулийн төсөл нь бусад хууль тогтоомжтой харилцан уялдсан байна.

Тав. Зөвлөмж

Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээг зохих журмын дагуу хийж гүйцэтгэхэд хуулийн төсөл зорилгодоо хүрэх боломжтой, хуулийн төсөл боловсруулах Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагад нийцүүлэн боловсруулжээ.

---oO---